

**ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН "ДОТООД ХЯНАЛТЫН БАГ"-ИЙН
2023 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН**

2023 оны 12 дугаар сарын 13

Хужирт сум

№	Арга хэмжээ	Хэрэгжилт, үр дүн	Үнэлгээ
1	Байгууллагын дарга, эрхлэгч нарын тушаал шийдвэрт тавих хяналт	Төсвийн 6 байгууллагын дарга, эрхлэгч нарын тушаал шийдвэрийг 3 удаа хянаж ажилласан. Хяналт шалгалтаар зарим байгууллагын дарга, эрхлэгч нарын тушаал хууль, эрх зүйн үндэслэлийг зөв оновчтой аваагүй, утга найруулга, үг үсгийн алдаатай, албан хэрэг хөтлөлтийн стандарт хангагдаагүй байсан. Тиймээс байгууллагын дарга, эрхлэгч, бичиг хэргийн ажилтнуудад Захирамжлалын баримт бичиг боловсруулах, албан хэрэг хөтлөлтийн стандартын талаар сургалт зохион байгуулж, зөвлөмж хүргүүлсэн. Зөвлөмжийн хүрээнд байгууллага бүр тушаалын хууль эрх зүйн үндэслэл, албан хэрэг хөтлөлтийн стандартыг хангахад анхаарч ажиллаж байна.	70%
2	Ерөнхийлөгчийн зарлиг, УИХ-ын тогтоол, Засгийн газрын тогтоол, албан даалгавар, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилт, хяналтанд авсан байдал, хувийн хэргийн баяжилтад хяналт шалгалт хийх	Байгууллага, албан хаагч бүр ажил үүрэгт хамраал бүхий хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг тухай бүр хяналтад авах, хэрэгжилтийг хангаж ажиллах, байнгын хэрэгжих тогтоол, шийдвэрүүдэд хувийн хэрэг нээж, баяжилтийг сайжруулах талаар албан хаагч бүрд арга зүйн зөвлөгөө өгч ажилласнаар 2023 оны жилийн эцсийн тогтоол, шийдвэрийн биелэлтийг тооцоход албан хаагчдын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд харьцангуй сайжирсан байна.	70%
3	4,5 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах Худгуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх	Сумын төвийн 4,5 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах гүний худгуудийн ариутгал хийгдэж байгаа эсэх, усны шинжилгээ улирал бүр хийгдэж, стандарт шаардлага хангаж байгаа эсэх, ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, нормын хувцасаар хангасан эсэхэд хяналт шалгалт хийсэн. Хяналт шалгалтаар гүний худгийн усны шинжилгээ, ариутгал тогтмол сайн хийгдэж байгаа ч Худгийн ажилчид эрүүл мэндийн үзлэгт хамрагдаагүй, мөн нормын хувцасаар хангагдаагүй байсныг илрүүлж Засаг даргын Тамгын газрын даргад зөрчил дутагдалыг арилгах талаар зөвлөмж хүргүүлсэн. Үүний дагуу Засаг даргын Тамгын газраас худгийн ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, нормын хувцсаар хангасан.	100%
4	Төрийн албан хаагчдын албан хэрэг хөтлөлт, бичиг хэргийн стандартад хяналт шалгалт хийх	Байгууллагын албан хаагчдын баримт бичиг албан хэрэг хөтлөлт, бичиг хэргийн стандартын шаардлага хангаж байгаад хяналт шалгалтыг хийхэд харьцангуй	70%

		стандартын шаардлага хангаж байгаа ч албан хэрэг хөтлөлтийн талаар сургалт зохион байгуулж нэгдсэн нэг стандарттай болгох үүднээс Архив, бичиг хэргийн ажилтнаар сургалт явуулж, арга зүйн зөвлөгөө, заавар өгч ажилласан. Ингэснээр албан хэрэг хөтлөлт, бичиг хэргийн стандарт сайжирч байна.	
5	Соёлын төв, Эмнэлэгийн албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтанд хяналт тавих	Сумын Соёлын төв, Эрүүл мэндийн төвийн албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтыг сайжруулах шаардлагатай байсан тул Засаг даргын Тамгын газрын Архив, бичиг хэргийн ажилтан албан хэрэг хөтлөлтийн стандартын талаар сургалт зохион байгуулсан. Мөн ажлын зохион байгуулалтыг сайжруулж, архив бичиг хэргийн ажилтныг чадваржуулах сургалтанд хамруулахыг дээрх 2 байгууллагын удирдлагад мэдэгдсэн.	70%
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих	Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албанд "Шилэн дансны хууль"-д заасны дагуу төсөв санхүүгийн ил тод байдал, цахим бүртгэл хийгдэж байгаа, цахим бүртгэлд оруулсан мэдээ тайлангаа холбогдох газарт хүргүүлж байгаа эсэхд шалгалтыг зохион байгуулсан. Шалгалтаар ямар нэгэн зөрчил гараагүй бөгөөд тус санхүүгийн алба нь хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж мэдээлэлийг ил тод, цахим бүртгэлийг тухай бүр хийж хэвшсэн байсан.	100%
6	Үндэсний болон аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилт	Үндэсний болон дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийхэд байгууллагуудын хөтөлбөр хариуцсан албан хаагчид үндэсний болон аймгийн дэд хөтөлбөрийг тухай бүр хяналтад авч хувийн хэрэг нээж хэвшсэн ч зарим хөтөлбөрийн хэрэгжилт төдийлөн сайн биш, хөтөлбөрийн баяжилт бүрэн хийгдээгүй байсан. Тиймээс албан хаагчдад хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах талаар зөвлөмж хүргүүлсэн. Зөвлөмжийг хэрэгжүүлж хөтөлбөрүүдийн хэрэгжилт, баяжилтийг сайжруулсан үр дүн жилийн эцсийн хөтөлбөрийн биелэлтээс харагдаж байна.	70%
7	Орон нутгийн өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хамгаалалтанд хяналт тавих	Орон нутаг хөгжүүлэх сангийн болон бусад чиглэлээр бий болсон өмч хөрөнгийг тухай бүр өмчийн бүртгэлд бүртгэж байгаа эсэх, тэдгээрийн ашиглалт, хамгаалалт хадгалалтад байгууллагын өмч хамгаалах комисс хэрхэн хяналт тавьж байгаад хяналт шалгалтыг явуулахад төрийн болон орон нутгийн хөрөнгө, төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр авсан өмч хөрөнгийг тухай бүрт нь бүртгэн үндсэн хөрөнгийн бүртгэлд авч хэвшсэн. Шинээр хөрөнгө авахдаа аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүсэлтээ	100%

		явуулж зөвшөөрсөн тохиолдол өмч хөрөнгийг авч байгаа. Мөн албан хаагч бүрийн ашиглаж байгаа эд хөрөнгийг албан хаагч тус бүр дээр картжуулан бүртгэсэн. Байгууллагын өмч хамгаалах комисс хагас, бүтэн жилээр эд хөрөнгийн тооллого явуулж, шинээр нэмэгдсэн хөрөнгийг нэмж бүртгэх, шилжүүлэх, цаашид ашиглах боломжгүй болсон хөрөнгийг устгах талаар комиссын хурлаараа хэлэлцэн шийдвэрлэж хэвшсэн байсан.	
8	Ёс зүйн хорооны үйл ажиллагаа, байгууллагын албан хаагчдын харилцааны ёс зүйд хийх дотоод хяналт шалгалт	Засаг даргын Тамгын газрын "Ёс зүйн хороо" нь 2023 оны ажлын төлөвлөгөө боловсруулан албан хаагчдын зан харилцаа, ёс зүйг дээшлүүлэх ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх талаар тодорхой ажлуудыг зохион байгуулж ажилласан байсан. Үүнд: "Төрийн албан хаагчийн ёс зүй", "Төрийн албан хаагчийн эрхэмлэх есөн зүйл", "Авлигын эсрэг хууль"-иадаар сургалт зохион байгуулж, "Төрийн албан хаагчийн эрхэмлэх есөн зүйл", "Нийтийн албан тушаалтан танд хуулиар юуг зөвшөөрч, юуг хориглосон бэ" гарын авлага бэлтгэн албан хаагчдад хүргэсэн байсан. Үүний үр дүнд 2018 онд Засаг даргын Тамгын газрын албан хаагчдаас ёс зүйн зөрчил, дутагдал гаргасан, хариуцлага тооцогдсон албан хаагч байхгүй.	100%
Дундаж			81.2

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ДОТООД ХЯНАЛТЫН БАГИЙН АХЛАГЧ

Л.ЦЭДЭВ

Л.ЦЭДЭВ

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

ХЯНАСАН:

З.ЦЭЦЭГМАА

З.ЦЭЦЭГМАА

